

## ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

Нэг. Албан ёсны статистик мэдээний хамралт, дамжуулалт

1.1 Мэдээний хамралт

1.2 Мэдээний дамжуулалт

1.3 Мэдээний бодит байдал, чанар

1.4 Хүн ам өрхийн бүртгэлийн мэдээллийн сан

1.5 Бизнес регистрийн мэдээллийн сан

Хоёр. Тооллого, судалгааны ажлын үр дүн

2.1 Мал тооллого

2.2 Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа

2.3 Ажиллах хүчний судалгаа

2.4 Эдийн засгийн түүвэр судалгаа

Гурав. Статистикийн мэдээлэл тархаалт, сургалт, сурталчилгаа

3.1 Сургалтын үйл ажиллагаа

3.2 Сурталчилгаа

3.3 Вэб баяжилт

3.4 Мэдээлэл тархаалт

Дөрөв. Төлөвлөлт, тайлагналт, хяналт үнэлгээ, санхүүгийн үйл ажиллагаа болон бусад ажлууд

4.1 Төлөвлөлт, тайлагналт

4.2 Хяналт үнэлгээний үр дүн өгөөж

4.3 Санхүүгийн үйл ажиллагаа

4.4 Бусад ажлууд

**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН  
ХЭЛТСИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2016 онд дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд статистикийн хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг судлан, тэдгээрт нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээгээр хангах ажлыг төлөвлөн хэрэгжүүлж, Монгол улсын Статистийн тухай хууль, төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхолын зөрчилгүй, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, боловсон хүчний чадавхийг бэхжүүлэн дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэн ажиллаж байна.

**БҮЛЭГ I. Албан ёсны статистикийн мэдээний бодит байдал, хамралт, дамжуулалт**

**Ш1: Мэдээний хамралт:** 2015 оны 12 сарын 30-ны өдрийн А/02 тоот тушаалаар баталсан аймагт мөрдөх “Албан ёсны статистикийн” мэдээний графикийн дагуу батлагдсан маягт аргачлалаар 54 төрлийн мэдээ, тайланг цуглуулан мэдээний тасалдал, хожимдол гаргаагүй ажиллалаа. Албан ёсны мэдээний хамралтыг өмнөх онтой харьцуулахад нийт дүнгээрээ 0.7 хувиар өссөн байна. Мэдээний хамралтын өсөлтөнд ААНБ-1 мэдээний хамралт 49.7 хувиар, ААНБ-2 мэдээний хамралт 56.5 хувиар, ЗГ-1а мэдээний хамралт 11.9 хувиар, ЗБ-1а мэдээний хамралт 21.4 хувиар, ББО-1 мэдээний хамралт 2.4 хувиар, ОС-1 мэдээний хамралт 30 хувиар, БР-1 мэдээний хамралт 3 дахин, ХАА-7а мэдээний хамралт 35 хувиар, ХАА-7б мэдээний хамралт 7 хувиар тус тус нэмэгдсэн байна. Харин өмнөх оноос ХАА-5 мэдээ 55.1 хувиар, БЗҮ-1а мэдээ 42.3 хувиар, ХҮ-1 мэдээ 23.4 хувиар, МЭ-1 мэдээ 40.6 хувь, АҮ-1 мэдээ 10.8 хувь, АЖ-1 мэдээ 10.8 хувь, ТББ-1,МТС-1,НБХҮ-1 мэдээнүүд 33.3 хувиар буурсан байна. Зарим салбарын мэдээний хамралт буурсан шалтгаан нь аж ахуй нэгж байгууллагууд нь санхүүгийн эх үүсвэрээс шалтгаалан түр зогссон, улирлын чанартай үйл ажиллагаа явуулдагтай холбоотой байна. Мэдээний хамралтыг нэмэгдүүлэхэд сар бүр хяналт тавин ажиллаж байна.

**Хүснэгт 1. Албан ёсны статистикийн мэдээний хамралт, өмнөх онтой харьцуулахад**

1	Мэдээ тайлангийн нэр	2015	2016	2016 % 2015
<b>НЭГ. АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭ, ТАЙЛАН</b>				
1	Аж ахуйн нэгж, байгууллагын 20... оны үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээ	165	247	149.7
2	Аж ахуйн нэгж, байгууллагын 20... оны үйл ажиллагааны хураангуй мэдээ	214	335	156.5
3	Мал төллөлт, төл бойжилтын мэдээ	450	450	100
4	Том малын зүй бус хорогдлын мэдээ	600	600	100
5	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн 20...оны .. сарын мэдээ	192	192	100

## Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс

6	Жимс, жимсгэний талбай, хураасан ургацын мэдээ	158	71	44.9
7	Тариалсан талбайн мэдээ	48	48	100
8	Газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжийн тариалсан талбайн ... оны жилийн эцсийн мэдээ	80	108	135
9	Газар тариалан эрхэлдэг өрхийн тариалсан талбайн ... оны жилийн эцсийн мэдээ	748	798	107
10	Ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэлийн мэдээ	748	748	100
11	Аж ахуйн нэгжийн хураасан ургацын эцсийн мэдээ	94	101	107
12	Өрх, хувиараа эрхлэх аж ахуйн хураасан ургацын эцсийн мэдээ	7427	7398	100
13	Мах боловсруулах үйлдвэрийн бэлтгэсэн малын мэдээ	1	1	100
14	Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 20... оны ... -р сарын мэдээ	216	174	80.6
15	Цахилгаан эрчим хүчний 20... оны баланс	1	1	100
16	Дулааны эрчим хүчний 20 ... оны баланс	1	1	100
17	Олборлосон нүүрсний 20.. оны баланс	1	1	100
18	Барилга, байгууламж, объектын 20... оны ... -р улирлын мэдээ	42	43	102.4
19	Авто, усан замын тээврийн 20... оны ...р улирлын тээвэрлэлтийн мэдээ	24	24	100
20	Агаарын тээврийн 20... оны ...-р сарын тээвэрлэлтийн мэдээ	-	-	-
21	Төмөр замын тээврийн 20... оны сарын тээвэрлэлтийн мэдээ	-	-	-
22	Шуудан, холбоо, интернетийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үйлчилгээний 20 ...оны улирлын тайлан	20	20	100
23	Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны ... оны ...-р улирлын мэдээ	47	36	76.6
24	Үйлчилгээний салбарын үнийн 20...оны...-р улирлын мэдээ	12	12	100
25	Худалдааны салбарын үнийн 20...оны...-р сарын мэдээ	120	120	100
26	Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн хүнсний гол нэр төрлийн барааны татан авалт, үлдэгдлийн 20... оны ...-р улирлын мэдээ	15	12	80
27	Зоогийн газрын үйл ажиллагааны 20... оны улирлын тайлан	59	66	111.9
28	Зочид буудлын үйл ажиллагааны 20 ...оны улирлын тайлан	28	34	121.4
29	Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-ын 20.. оны улирлын мэдээ	37	33	89.2
30	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 20... оны гүйцэтгэл	1	1	100
31	Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн 20..оны .. -р сарын мэдээ / УБ/	-	-	-
32	Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн 20... оны .. -р сарын мэдээ / Аймаг/	12	12	100
33	Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн 20.. оны ..-р сарын мэдээ	12	12	100
34	Мал эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн 20 .. оны.. -р улирлын мэдээ	160	95	59.4
35	Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхэлдэг ААНБ-ын үйл ажиллагааны 20... оны... улирлын мэдээ	26	15	57.7
36	Аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийн улирлын мэдээ	28	92	328.6
37	Салбар, охин, толгой компаний бүртгэлийн мэдээ	-	-	-
38	Төрийн бус байгууллагын 20... оны ...-р улирлын мэдээ	90	60	66.7
39	Нийтийн орон сууцны үнийн 20... оны ...-р сарын мэдээ	-	-	-
40	Нийгэм, бие хүнд үзүүлэх үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийн 20... оны ...-р улирлын мэдээ	12	8	66.7

## Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс

41	Хот, нийтийн аж ахуй үйлчилгээний 20... оны жилийн мэдээ	16	16	100
42	Нийгмийн зарим үзүүлэлтийн 20... оны мэдээ	16	16	100
43	Хүн амын ердийн хөдөлгөөний хагас жил, жилийн ... оны тайлан	32	32	100
44	Хүн амын шилжих хөдөлгөөний жилийн эцсийн тайлан	16	16	100
45	Суурин хүн амын 20...оны жилийн эцсийн тайлан	75	75	100
46	Мэргэжлийн түр сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны ..-р улирлын мэдээ	18	12	66.7
47	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн 20... оны ...-р улирлын мэдээ	-	-	-
48	Чөлөөт цаг, соёл, биеийн тамирын үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн 20... оны ...-р улирлын мэдээ	-	-	-
49	Сүм хийдийн үйл ажиллагааны 20... оны ...-р улирлын мэдээ	16	16	100
50	Сонин, сэтгүүлийн 20.. оны жилийн эцсийн мэдээ	-	-	-
51	Хэвлэгдсэн ном товхимлын 20.. оны жилийн эцсийн мэдээ	-	-	-
52	Орон сууц, нийтийн аж ахуйн 20...оны ..-р улирлын мэдээ	-	-	-
53	Ашиглалтанд оруулсан орон сууцны 20...оны хагас/бүтэн жилийн мэдээ	30	39	130
54	Ашигт малтмалын дотоодын зах зээлийн ... сарын үнийн мэдээ	-	-	-

### Ш2. Мэдээний дамжуулалт:

Үндэсний Статистикийн хорооны даргын 2015 онд баталсан графикийн дагуу, мэдээ тайланг хугацаанд нь бүрэн дамжуулж, мэргэжилтэн бүр хаиуцсан салбарын мэдээний бүртгэлийг хөтөлж, хянаж шалган онлайн болон офлайн программд шивж, цахим хэлбэрээр [medee@nso.mn](mailto:medee@nso.mn) хаягаар дамжуулж, сум, аж ахуй нэгж байгууллагаас [bulgan@nso.mn](mailto:bulgan@nso.mn) хаягаар мэдээ тайланг хүлээн авч хэвшсэн. Сум болон аж ахуй нэгж байгууллагуудаас цахимаар графикт мэдээг авч хэвшсэнээр мэдээ тайлангийн хугацаа хоцролт эрс буурсан.

### Ш3. Мэдээний бодит байдал:

Анхан шатны нэгжээс мэдээ цуглуулахдаа мэдээний үнэн бодит байдал, баталгаажуулалт, өмнөх сар, улирал, өмнөх онтой харьцуулалт хийн хянаж шалган боловсруулан дамжуулж ажиллаж байна. 2016 оны 2 сард хөдөө аж ахуйн мэдээ, тайлангийн хяналт, шалгалтыг Дашинчилэн, Гурванбулаг, Хутаг-Өндөр сумуудад хийж гарсан зөрчил дутагдлыг арилгуулан, заавар зөвлөмж өгч ажилласан.

- 5-р сард Статистикийн хэлтсийн даргаар батлуулсан “Сумдад ажиллах удирдамж”-ийн дагуу Могод, Рашаант, Баяннуур сумдын анхан шатны мэдээ тайлангийн бодит байдалд хяналт шалгалт хийж гарсан алдаа зөрчлийг засуулан зөвлөн тусалж ажилласан.
- ХАӨМСангийн хяналт шалгалтыг суманд ажиллах удирдамжийн дагуу Хутаг-Өндөр, Могод, Баяннуур, Рашаант сумдад 5 сарын 25-аас 6 сарын 7 хүртлэх хугацаанд хийсэн. Хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг тухай бүр нь засуулж ажилласан. Нийтлэг

гарч байгаа алдаа нь шинээр төрсөн хүүхдийн мэдээлэл, өрхийн үзүүлэлтийн бөглөлт дутуу, нас барсан иргэний хасалт, 2, 6, 11, 15, 16, 18, 40 насны иргэдийн өөрчлөлт хөдөлгөөнийг ажиллах хугацаандаа бүрэн хийлгэсэн.

- 8-р сард аж үйлдвэрийн салбарын мэдээнд Булган суманд үйл ажиллагаа явуулж байгаа Арвай нарийн боовны цех, Дэлгэрэх нарийн бооны цех, Булган кашмер ХХК-д сар бүрийн мэдээнд хамрагдсан мэдээний бодит байдалд хяналт хийн аж ахуй нэгжүүдийн дарга болон нягтлан нарт гарсан алдаанд нь сануулга өгч мэдээг цаашид сар бүр графикт хугацаанд нь үнэн зөв гаргаж мэдээллэж байхыг үүрэг болгон ажиллаа.
- Статистикийн хэлтсийн даргаар батлуулсан удирдамжийн дагуу Булган сумын 1,2,3,4,6-р багт нийт 14 өрхийн тариалсан талбай, хураасан ургацын мэдээнд хяналт шалгалт хийж ажилласан. Хяналтаар 1 өрх огт тариалалт байхгүй, 2 өрхийн тариалсан талбайн хэмжээ өгсөн мэдээнээс бага гарсан зэрэг зөрчил дутагдал гарсныг багийн дарга, ХАА-н мэргэжилтэн болон төсвийн мэргэжилтэнд сануулга өгч цаашид зөрчил дутагдал гаргахгүй ажиллахыг анхааруулж заавар зөвлөмж өгч ажилласан.
- Статистик бүртгэл, мэдээллийн ажлыг анхан шатанд сайжруулан, мэдээ тайлангийн үнэн бодит байдал, хамралтыг нэмэгдүүлж, аймгийн нийгэм эдийн засгийн цар хүрээг харуулахад тодорхой үүрэг гүйцэтгэж, идэвхи санаачлагатай ажилласан аж ахуй нэгж байгууллагыг шалгаруулж “Тэргүүний мэдээлэгч байгууллага” батламжийг гардуулж, мэдээлэгч нарт урам өгөх ажлыг зохион байгуулсан. Батламжийн эзнээр ахуй үйлчилгээний салбарын “Дахин сэргэлт” төрийн бус байгууллага, Бүрэгхангай сумын ЗДТГазар шалгарлаа.

#### **Ш4: Хүн ам өрхийн мэдээллийн сан:**

Хүн ам өрхийн мэдээллийн сан”-г Улсын бүртгэлийн хэлтсийн “Иргэний бүртгэлийн сантай” тулгах ажлыг хийж байна.

1. НХҮЕГ-ын өрхийн амьжиргааны санд бүртгэгдсэн боловч ХАӨМС-д байхгүй. 76 хүнийг тодруулахад 11-нь нас барсан, 25нь өөр регистрын дугаараар ХАӨМСанд бүртгэгдсэн, 7 хүн огт олдохгүй, тодорхойгүй, 12-нь ХАӨМСанд бүртгэлтэй, 17-нь албан ёсоор шилжээгүй боловч өөр аймагт амьдарч байгаа иргэд байна.
2. ИБСанд байхгүй ХАӨМСанд байгаа 265 хүнийг тодруулахад 69 иргэн нь нас барсан, 78 иргэн тодорхойгүй, 10 иргэн хүчингүй регистртэй, 108 иргэний мэдээлэл байна.
3. ИБ-ийн цэвэр санд байгаа ХАӨМСанд байхгүй 65 иргэнийг тодруулж, 60 иргэнийг ХАӨМСанд нэмсэн бол, 1 хүн нас барсан, 1 хүн давхар бүртгэлтэй, 3 иргэн олдоогүй.
4. MEDS хаягтай 21 иргэнийг ХАӨМСанд нэмж оруулсан.
5. Төрөлтийн санд бүртгэлтэй ХАӨМСанд байхгүй 94 хүүхдийг нэмсэн.
6. Өрхийн эмнэлэгт хаягтай ХАӨМСанд байхгүй 33 иргэний мэдээллийг тодруулж, 12 иргэнийг нэмсэн бол 21 иргэн огт олдохгүй шалтгаантай байна.
7. Эрүүл мэндийн яамны мэдээллийн санд амаржсан ХАӨМСанд байхгүй 16 хүний иргэнийг тодруулахад 10 иргэний ЭМЯны мэдээллийн сангийн бүртгэл алдаатай байсан бол 6 хүний мэдээлэл огт олдоогүй.

8. ИБ-ийн том санд байгаа ХАӨМСанд байхгүй 110 хүний мэдээллийг тодруулахад 16 иргэний мэдээлэл олдохгүй, 3 иргэн нас барсан, 1 иргэн давхар бүртгэлтэй, 1 иргэн нэрээ солиулсан, 1 иргэн шилжсэн, 88 иргэнийг шинээр бүртгэсэн.

9. ИБ-ийн санд хүчингүй төлөвтэй ХАӨМСанд байгаа 6 хүнийг тодруулахад 1 иргэн тухайн хаягийн мэдээлэл ИБСанд алдаатай, 5 регистрийн дугаараар сольсон хүчингүй регистртэй байсан зөрчлийг арилгалаа.

10. 3-р сарын 16-ны нэмэлт тодруулгаар 52 иргэний мэдээллийг тодруулахад 49 иргэн ХАӨМСанд буруу регистрээр бүртгэсэн ХАӨМСангаас устгуулах мэдээллүүд байсан бол 3 иргэнийг ХАӨМСанд бүртгэсэн.

11. Нас баралтын санд бүртгэлтэй боловч ХАӨМСанд амьд төлөвтэй 79 хүний тодруулгыг хийхэд бүгд нас барсан тул, нас баралтыг бүртгэсэн.

12. 16 ба түүнээс дээш насны ХАӨМСанд байхгүй 117 иргэний мэдээллийг тодруулж, 50 иргэнийг бүртгэж, 11 иргэн ХАӨМСанд өөр бүртгэлтэй, 12 иргэн албан ёсоор шилжин явсан, 18 иргэн хаягандаа амьдардаггүй, 25 нас барсан, 1 амьд боловч нас барсан төлөвт байсныг засварлалаа.

Мөн хүн ам өрхийн мэдээллийн санд 2016 оны 5-р сар хүртэл шинээр төрсөн 386 хүүхдийг шинээр бүртгэж, 181 нас барсан тул төлөвийг өөрчлөх ажлыг багийн дарга нартай хамтран хийж ажиллалаа. ХАӨМСангийн нас дэвшилтийн завсрыг хийж байна.

### **Ш5: Бизнес регистрийн мэдээллийн сан:**

ААНБУлсын ээлжит тооллогыг 4-р сарын 1-нээс 30-ны өдрүүдэд нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, 1384 аж ахуйн нэгж байгууллага, салбарыг тооллогод бүрэн хамрууллаа. Нийт тоологдсон 1384 ААНБ, салбарын 3.5 хувь нь татан буугдахаар хүлээгдэж байгаа, 0.3 хувь нь эзэн нь нас барсан, албан ёсны өмчлөгч байхгүй, 0.2 хувь нь олдохгүй, 0.2 хувь нь нууцын зэрэглэлтэй, 0.4 хувь нь давхар байгаа бүртгэлтэй, 2.7 хувь нь бусад шалтгаантай байна. Тооллогын хүрээнд статистикийн “Бизнес регистрийн сан”-д бүртгэлтэй байгаа аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг, улсын бүртгэлийн хуулийн этгээдийн санд бүртгэлтэй ААНБ-ийн мэдээлэлтэй тулгалт хийж, зөрүүг тодруулан ажиллалаа. Статистикийн “Бизнес регистрийн сан”-д 2015 оны жилийн эцэст байсан 1228 аж ахуй нэгж байгууллагын бүртгэлийг, улсын бүртгэлийн хуулийн этгээдийн сангийн хувийн хэргийн тооллогоор тоологдсон 1256 аж ахуй нэгж байгууллагын бүртгэлтэй тулгаж зөрүүг тодруулахад хуулийн этгээдийн санд бүртгэлтэй 15 аж ахуйн нэгж байгууллага нь аймгийн Гааль, татварын газраас татан буулгасан, 13 нь хуулийн этгээдийн санд бүртгэлтэй боловч статистикийн “Бизнес регистрийн сан”-д бүртгэлгүй аж ахуй нэгж байгууллага байсныг ААНБУТооллогын хугацаанд бүртгэлжүүлж ажиллалаа.

2016 онд аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтэстэй хамтран шинээр байгуулагдсан ААНБ-ыг БР-1, БР-2 маягтуудаар бүртгэн, нийт.....ААНБын тодруулгыг хийж ажиллалаа. Цаашид холбогдох газруудтай уялдаа холбоотой ажиллаж шинээр байгуулагдсан ААНБ-ыг бүртгэх, мэдээ тайланд хамруулан ажиллаж байна. Devinfo программд 19 салбарын 147 багц үзүүлэлтээр 17 засаг захиргааны нэгжийн мэдээллийг шивж оруулан, баяжилтыг тухай бүр нь хийж ажиллаж байна.

### БҮЛЭГ II. Тооллого, судалгааны чанар үр дүн

#### Ш6: Мал тооллого:

Хагас жилийн мал тооллого: УБСЕГазрын даргын 2016 оын 06 сарын 09 -ны 1/354 тоот албан бичгийн дагуу хагас жилийн малын түүвэр судалгаа, ХАА-н өртөг зардлын судалгааг нутаг дэвсгэрийн хэмжээнд амжилттай зохион байгуулан явуулсан. Малын түүвэр судалгаанд хамрагдсан малчин өрхүүдээс дэд түүвэр хийж ХАА-н бүтээгдэхүүний орлого, зардлын судалгааны мэдээллийг давхар цуглуулах бэлтгэл ажлыг бүрэн хангаж энэ удаагийн тооллого нь УИХ болон аймгийн иргэдийн төлөөлөгчдийг сонгох ээлжит сонгуультай давхцаж байгаа тул “Сонгуулийн тухай” хуулийн 70 дугаар зүйлд заасан хориглосон үйл ажиллагаа явуулахгүй байхыг анхааруулан ажилласан. Аймгийн Засаг даргын орлогч даргын 02/507 тоот албан бичгээр сумдын Засаг дарга нарт үүрэг өгч, статистик хариуцсан ажилтнуудад тооллогын онлайн программ, заавар зөвлөгөө, малын түүвэр судалгаа, ХАА-н өртөг зардлын судалгаануудад хамрагдсан өрхийн жагсаалт, тооллого, судалгааны маягыг хүргүүлж тухай бүр удирдлагаар хангаж ажиллаа. Малын хагас жилийн түүвэр судалгаанд нийт 1643 өрх хамрагдсан. Үүний 450 өрхөөс мал аж ахуйн үйлдвэрлэлийн 2015 оны орлого, зардлын судалгааг, (маягт ХААТС2а), газар тариалан эрхэлдэг 200 өрхөөс газар тариалангийн үйлдвэрлэлийн 2015 оны орлого, зардлын судалгааг (маягт ХААТС-2б) маягт аргачлалын дагуу цуглуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаа. Тооллого 6 сарын 15-22-ны өдрүүдэд явагдаж, нийт 1623 өрх, 20 аж ахуй нэгж байгууллага хамрагдахаас 1619 өрх, 20 аж ахуй нэгж байгууллага хамрагдаж мэдээллийг тооллогын программд хугацаанд нь шивж, хянаж, шалган ҮСХороонд дамжуулсан.



Жилийн эцсийн мал тооллого: Аймгийн Засаг даргын 2016 оны 11-р сарын 30-ны өдрийн А/511 тоот захирамжийн дагуу 2016 оны жилийн эцсийн мал тооллогын ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах үүрэг чиглэлийг сумдын удирдлагад өгч, тооллогын комиссын дарга, Засаг даргын орлогч Ц.Бат-Өлзийгөөр ахлуулсан ажлын хэсэг хэрэгжилтэнд хяналт тавин ажиллалаа.



Хяналтын тооллогыг Статистикийн хэлтсийн дарга Ц.Мөнхбат, Цагдаагийн Газрын дэд дарга Гантөмөр, АЗДТГ-ын ХБХэлтсийн мэргэжилтэн Г.Бадамсүрэн, ҮХААГ-ын дарга Ч.Амгалан, нараар ахлуулсан 4 чиглэл 12 сарын 08-ноос 12-ны өдрүүдэд хяналтын тооллогыг бүх сумдад зохион байгууллаа. Сумдын хяналтын тооллогын комисс . . . өрхөд, аймгийн тооллогын комисс . . . өрхөд, нийт . . . өрхөд хяналтын тооллогыг хийлээ. Гарсан зөрчил алдаа, дутагдлыг газар дээр нь засуулж, ололттой талуудыг сайшааж ажилласан нь үр дүнгээ өглөө. Мал тооллогод аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 3024.7 мянган төгрөг, сумдын Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 16281.6 мянган төгрөг, нийт 19306.3 мянган төгрөгийг зарцуулсан байна. Мал тооллогын үйл ажиллагаанд 660 албан хаагч, ажиллаж 120 автомашин үйлчилсэн байна.

2016 оны 12 сарын 10-ны өдөр ҮСХороо, ХХААЯамтай хамтарсан улсын мал тооллогын хяналтанд манай аймаг сонгогдож, ҮСХорооны олон нийттэй харилцах албаны референт Дамдин, ХХААЯамны мэргэжилтэн Амартүвшин нар Орхон, Хутаг-Өндөр сумдад мал тооллогын явц, өвөлжилтийн байдал, хүндрэл бэрхшээл, маягтын нөхөлт, үнэн бодит байдалтай танилцан, ажлын төгсгөлд аймгийн Засаг даргатай уулзан мал тооллогын ажлын явц, хяналт, шалгалтын дүнг сайн зохион байгуулагдаж байна гэсэн дүгнэлтийг танилцуулсан.

### Ш7: Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа:

ҮСХорооны даргын 2011 оны 12-р сарын 23-ны өдрийн 01/193 дугаар тушаалаар баталсан “Судалгааны мэдээлэл цуглуулах баг”-ийн журам, “Хөдөлмөрийн хууль”, хэлтсийн “Хөдөлмөрийн дүрэм, дотоод журам, судалгааны аргачлал зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллалаа. Тайлант хугацаанд ӨНЭЗС-н судалгаа, Ажиллах хүчний судалгаа, Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн судалгаа, Ногоон ажлын байрны судалгаа, Улирал тутамд хийгддэг Ардчилсан засаглал судалгааны мэдээллийг өрхөөс таблет ашиглан бүрэн цуглуулж ажиллалаа. ӨНЭЗСудалгаанд сонгогдсон өрхөд олгох мөнгөн урамшуулал 1248.0 мян.төгрөгийг бүрэн олгож, мэдээлэл цуглуулахад 24084 км явж, 3612,9 л шатахуун зарцуулсан. Өрхийн судалгааны алдаа өмнөх оныхтой



харьцуулахад 21,4 хувиар буурсан байна. Анхан шатны нэгжээс цуглуулсан мэдээллээ дахин хянаж, бүлэг хоорондын уялдаа холбоо, балансыг шалган, төвийн өрхийн дэвтрийг 10, 10 хоногоор судалгааны ахлагчид хянуулан гарч байгаа алдааг дор бүр нь тодруулж, цаашид алдаа гаргахгүй байх талаар анхаарч ажиллаж байна. Мэдээлэл цуглуулахдаа нөөц өрхийг сонгохгүй байхад анхаарч, зайлшгүй сонгох тохиолдолд ахлагчид мэдэгдэж, үндсэн өрхийн шалтгааныг багийн Засаг даргаар баталгаажуулан ажиллаж байна. Өрхийн жагсаалтыг сар бүр багийн Засаг даргаар гаргуулан, түр эзгүй байгаа өрхүүдийг тодруулан

ажилласнаар 2016 оны байдлаар нөөц өрхийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 24 хувиар буурсан байна. Судлаач нарын аюулгүй байдалд анхаарч сумдад ажиллахад



багийн Засаг дарга нарт хэлтсийн даргын талархлыг хүргүүлэн, судлаач нарыг статистикийн лого бүхий хантаазтай болгосон нь иргэд албан ажлаар ажиллаж байгааг мэдэх, төрийн албаны соёлыг харуулсан ажил боллоо. Мөн судлаач нарын мэдээлэл цуглуулах болон хяналт шалгалт хийх жилийн төлөвлөгөөг батлан ажлын ачааллыг жигд хуваарилснаар өрхийн алдаа буурч, чанарт ахиц гарсан гэж дүгнэж байна. ҮСХорооны даргын өрхөд хүргүүлж байгаа ӨНЭЗСудалгааны “ТАЛАРХАЛ”-ын ар талын хуудсанд, Ажиллах хүчний судалгааны сонгогдсон өрхөд “Танилцуулга” хэлбэрээр “Булган аймгийн нийгэм эдийн засгийн үзүүлэлт”-ийг хэвлэн хүргэх ажлыг судлаач

нар санаачлан хийж байна. 2016 оны байдлаар 725 өрхөд мэдээллийг тархаасан байна.

### Ш8: Ажиллах хүчний судалгаа:

Ажиллах хүчний судалгаанд 36 багийн 432 өрхөөс таблет ашиглан мэдээллийг хугацаанд нь чанартай цуглуулах ажлыг зохион байгуулж өрхөд олгох мөнгөн урамшуулал



864.0 мянган төгрөгийг бүрэн олгож, мэдээлэл цуглуулахад 10752 км явж 1612,9 л шатахуун зарцуулсан.

2016 оны байдлаар Ажиллах хүчний судалгаанд 11 нөөц өрх сонгогдсон нь өмнөх оны мөн үеийнхээс 8 өрхөөр буюу 42,1 хувиар буурсан байна. Судалгааны алдаа тодруулга өмнөх оноос 24,2 хувиар буурсан байна. Судалгааны зардлыг үр өгөөжтэй зарцуулахад анхаарч, багт ажиллахдаа өрх хоорондын км маршрутыг гарган, багийн Засаг даргаар баталгаажуулан ажиллаж байна.

### Ш9: Эдийн засгийн түүвэр судалгаа:

2016 онд хийгдсэн судалгаануудыг нутаг дэвсгэрийн хэмжээнд удирдамж, заавар, чиглэлийн дагуу хугацаанд нь зохион байгуулан явууллаа.

**\*\* Аж ахуй нэгж байгууллагын улсын тооллого:** Аймгийн Засаг даргын орлогч даргаар ахлуулсан ажлын хэсгийн хурлыг хуралдуулж тооллого зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлууллаа. Тооллогод ажиллах шалгагч тоологч нарын сургалтыг 2016 оны 03-р сарын 29-ны өдөр Булган суманд зохион байгуулж, сургалтанд нийт 34 хүн оролцсон. Аймгийн хэмжээнд 16 сум 1 тосгонд удирдамж, чиглэл, тооллогын материалыг хүргүүлж, сумын тооллогын комисс томилогдон, ажлын төлөвлөгөө гарган, тооллогын

## Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс

бэлтгэл ажлыг хангуулан ажилласан. ААНБТ-ын аймгийн комиссын үйл ажиллагааны талаар: “Аж ахуй нэгж байгууллагын улсын ээлжит тооллого”-ын аймгийн комиссыг аймгийн засаг даргын 2016 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн А/134 тоот захирамжаар байгуулан, аймаг, сумдын тооллогын комисст тооллогын ач холбогдол, тооллогын зорилгыг тайлбарлан таниулж ажилласан бөгөөд тооллогод хамрагдах аж ахуй нэгж байгууллагын тооллогын хүрээг сум тус бүрээр хүргүүлсэн. Мэргэжилтнүүд хариуцсан сумын ААНБТ-н сумын комисс, холбогдох ажилтнуудыг өдөр тутмын удирдлага зохион байгуулалтаар ханган ажилласан.



ААНБТ-ын хяналт шалгалтын талаар: Статистикийн хэлтсийн мэргэжилтэнүүд тооллогын хугацаанд хариуцсан сумын ААНБТ-ын хянагч, шалгагч нарт заавар зөвлөмж өгч, гарсан алдаа дутагдлыг цаг тухай бүр нь залруулан, зохих арга хэмжээ авч ажилласан. УБСЕГ-ын ТСМГазрын ахлах мэргэжилтэн М.Оюун, ҮТХэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Энхзаяа, Статистикийн хэлтсийн дарга Ц.Ганцэцэг нар Булган, Хутаг-Өндөр сумдад аж ахуй нэгж байгууллагын улсын ээлжит тооллогын хяналт шалгалтаар хамтран ажиллалаа.



Нийт тоологод хамрагдсан 1384 ААНБ, салбарын 727 онлайнаар, 657 уламжилалтаар нийт тооллогод хамрагдаад байна. Тооллогод хамрагдсан ААНБ, салбарын 38 бусад шалтгаантай, 6 давхардсан, 2 нууцын зэрэглэлтэй, 49 татан буугдахаар хүлээгдэж байгаа, 3 хаяг утас тодорхойгүй, 4 захиарл эзэн нас барсан шалтгаантай байна. Тооллогын хамралт 100 хувь. Мөн хуулийн этгээдийн санд бүртгэлтэй 1256, статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй 1249 аж ахуйн нэгж, байгууллагын тулгалтыг хийж давхардсан болон, татан буусан аж ахуй нэгж байгууллагыг мэдээллийн сангаас хасалт хийн ажилласан.

**\*\* Нөөц ашиглалтын судалгаа, Салбар хоорондын тэнцэл судалгаа:** Улсын хэмжээнд 5 жил тутамд хийгддэг “Нөөц, ашиглалтын хүснэгт, салбар хоорондын тэнцэл” (СХТ, НАХ)-г зохиох судалгааны онлайн сургалтанд 5 дугаар сарын 27 нд хэлтсийн мэргэжилтнүүд хамрагдсан. СХТ, НАХ судалгааг 46 аж ахуйн нэгж байгууллагаас 5 сарын 30-наас 7 сарын 8-ны хооронд мэдээллийг цуглуулан хянаж шалган ҮСХ-нд маягтаар нь хүлээлгэн өгч ажилласан.


\*\* Зочид буудал, зоогийн газрын судалгаанд 2 нэгж сонгогдож, судалгааг батлагдсан маягтаар цуглуулан дамжууллаа.

\*\* Үйлдвэрлэгчийн үнийн индексийн судалгааг 2 аж ахуйн нэгжээс цуглуулан дамжуулсан.

\*\* Худалдааны салбарын үнийн индекс тооцоонд ашиглах суурь үнэ цуглуулах судалгаанд сар бүр 10 аж ахуйн нэгж сонгогдож мэдээллийг батлагдсан маягтаар авч хугацаанд нь дамжуулж ажиллалаа.

\*\* **Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгаа:** ҮСХ-ны 2016 оны 09 сарын 28-ны өдрийн 08/176 тоот албан бичгийн дагуу Далд эдийн засгийн тооцоог сайжруулах ажлын хүрээнд “Хувиараа хөдөлмөр эрхлэх үйл ажиллагааны хүрээ тогтоох судалгаа”-г өмчийн бүх хэвшлийн аж ахуй нэгж, байгууллага болон хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдийн мэдээллийг цуглуулан хугацаанд нь дамжуулан ажилласан. Судалгаанд түрээслэгч 143 иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч 753 иргэн судалгаанд хамрагдсан.

\*\* Бичил уурхайн судалгаа: Улсын хэмжээнд 5 жил тутамд хийгддэг “Бичил уурхайн судалгаа”-ны сургалтанд 9 дугаар сарын 21-нд хэлтсийн мэргэжилтэн Б.Болормаа хамрагдсан. Тоологчийн сургалтыг 10 сарын 06-нд Бүрэгхангай сумын төсвийн мэргэжилтэн Д.Оюунгэрлд судалгааны сургалт хийсэн. 10 сарын 10-наас судалгааг эхлэн 43 иргэнээс мэдээллийг цуглуулан хянаж шалган ажиллаж байна.



\*\* Улаанбурхан, улаануудийн эсрэг дархлал тогтцын судалгаа: Үндэсний статистикийн хороо Эрүүл мэндийн яамтай хамтран “Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг дархлал тогтцын судалгаа”-г ДЭМБ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан. Судалгаанд ажиллах шалгагч, тоологч нарыг 11 сарын 14-ны өдөр ҮСХ-оос зохион байгуулсан онлайн сургалтанд хамруулж 11 сарын 19-өөс 28-ны өдрүүдэд Булган аймгийн Булган сумын 6-р багийн 47 өрхийн судалгааны мэдээллийг цуглуулж цаг хугацаанд нь мэдээллийг ҮСХ-нд дамжуулан ажиллалаа.



### БҮЛЭГ III. Статистикийн мэдээлэл тархаалт, сургалт сурталчилгаа:

#### Ш10: Сургалтын үйл ажиллагаа:

Хэлтсийн жилийн сургалтын төлөвлөгөөг боловсруулан газрын даргаар батлуулан



төлөвлөгөөний дагуу сургалтын үйл ажиллагааг зохион байгуулан, тайланг графикт хугацаанд УБСЕГ-т дамжуулан ажиллаж байна.

2-р сарын 2-нд Булган, Могод, Сайхан, Хангал, Тэшиг, Баян-агт, Орхон, Бүрэгхангай сумдын 30 багийн Засаг дарга нарт “Хүн ам өрхийн мэдээллийн сангийн анхаарах асуудал” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтын гол зорилго нь ХАӨМСан, мал



тооллогын мэдээллийн сангийн малтай, малчин өрхийн мэдээллийг тулгах, ХАӨМСангийн хандалт, ашиглалтыг сайжруулах, өөрчлөлт хөдөлгөөнийг хийх, бусад цаг үеийн тооллого, судалгааны анхаарах асуудлын талаар заавар зөвлөмж өгч ажилласан.

2-р сарын 7-8-ны өдрүүдэд зохион байгуулсан аймгийн “Удирдах ажилтны

шуурхай зөвлөгөөн”-д хэлтсийн дарга Ц.Ганцэцэг “Монгол улсын Статистикийн тухай хууль”, “Статистикийн байгууллагын үйл ажиллагаа” статистикийн байгууллагаас зохион байгуулж байгаа цаг үеийн тооллого, судалгаа, 2016 оны мэдээ, тайлангийн графикийг танилцуулж, мэдээ тайланг эзэнжүүлэн, анхдагч мэдээ, тайлангийн чанарт




## Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс

анхаарч ажиллахыг үүрэг чиглэл өглөө. Сургалтанд нийт 50 гаруй удирдах ажилтнууд оролцлоо.

2-р сарын 22-23 өдрүүдэд Улсын бүртгэлийн сумдын ажилтнуудыг чадавхижуулах” сургалтыг Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран зохион байгуулсан. Сургалтыг хэлтсийн дарга Ц.Ганцэцэг “Бүртгэл, статистикийн байгууллагын тогтолцоо, ААНБ-ын тооллогын тухай”, мэргэжилтэн Ц.Батчимэг “Хөдөө аж ахуйн салбарын статистикийн мэдээ тайлангийн тухай, аргачлал, анхаарах асуудал “2016 оны статистикийн мэдээ тайлангийн график танилцуулах”, мэргэжилтэн Б.Болормаа “Мэдээлэл тархаалт, сургалт сурталчилгаа, динамикийн тухай ойлголт”, гэрээт ажилтан Ж.Мөнхзул “Үйлчилгээний салбарын статистик мэдээний тухай анхаарах асуудал” сэдвүүдийг заасан. Мөн тооллого, судалгаа, статистикийн үйл ажиллагаа, Монгол улсын “Статистикийн тухай” хуулийн талаар танилцуулж, 2016 оны мэдээ, тайлангийн маягт, статистикийн арга аргачлалын цуврал гарын авлагыг тарааж, албан хэрэгцээнд ашиглах заавар зөвлөмжийг өгч ажиллалаа. Сургалтанд нийт 16 улсын бүртгэгч, улсын бүртгэлийн хэлтсийн зарим ажилтнууд, оролцсон.



Сургалтанд оролцогчдоор хөдөө аж ахуй, аж үйлдвэр, барилгын салбарын батлагдсан маягтаар мэдээ тайлан гаргуулж, хяналт шалгалт хийх дадлага ажлыг хийлгэж ажилласан.




3-р сарын 29-ны өдөр Монгол улсын “Статистикийн тухай ” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “з”, Монгол Улсын засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 21-ны өдрийн “Аж ахуй нэгж байгууллагын тооллогын тов тогтоох тухай” 163 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2016 оны 03 дугаар сарын 28-ны А/134 дүгээр захирамжийг мөрдлөг болгон, “ААНБ-н тооллогыг зохион байгуулах” сэдэвт сургалтыг сумын төсвийн мэргэжилтэн, улсын бүртгэгч нийт 34 албан хаагчдад зохион байгууллаа. Сургалтаар хэлтсийн дарга

## Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс

Ц.Ганцэцэг “ААНБ-н ерөнхий асуудал”, “Мэдээллийн технологи, толгой, охин хараат салбар төлөөлөгчийн газар”, “Эдийн засгийн үзүүлэлт”, “ТББ-ийн чиг үүрэг”, мэргэжилтэн Г.Нандин “Тоологч шалгагчийн үүрэг, баримтлах, зарчим”, “Асуулгыг үнэн зөв шалгаж, кодлох”, гэрээт ажилтан Б.Нямсүрэн “Онлайн программын тухай”, “Тооллогын газрын зураг, төлөвлөлт” сэдвүүдээр хичээл заан, удирдамж, чиглэл өгч, анхаарах асуудал, тооллогын маягт хүлээлгэн өгч ажиллалаа.



3-р сарын 29-ны өдөр зохион байгуулсан “Сумдын статистикийн мэдээ хариуцсан ажилтнуудад зориулсан сургалт”-аар мэргэжилтэн Б.Болормаа “Хөдөө аж ахуйн мэдээ, тайлан гаргах аргачлал”, мэргэжилтэн Г.Нандин “Монгол улсын Статистикийн тухай хууль”, УБСЕгазраас зохион байгуулж байгаа цаг үеийн тооллого, судалгааны талаар дэлгэрэнгүй танилцуулж, анхдагч мэдээ, тайлангийн чанарт анхаарах, цаашид хийгдэх ажлын тухай чиглэл өглөө. Сургалтанд нийт 33 ажилтан оролцов. Сургалтанд оролцогчдоос цаашид ямар сургалт авах санал, асуулга авсан. Санал асуулгад мэргэжил арга зүйн зөвлөгөө, заавар өгөх сургалтыг улирал бүр зохион байгуулах, сумдад мэдээ,



тайланг онлайнар шивэхэд өндөр хурдтай компьютер, тоног төхөөрөмжийн асуудлыг шийдвэрлэх талаар анхаарч ажиллахыг санал болголоо. Энэ удаагийн сургалт ач холбогдолтой, чанартай цаг үеэ олсоныг ихэнх оролцогчид тэмдэглэсэн байна.

2016 оны 05-р сарын 13-ны өдөр “Үйлчилгээний салбарын статистик хариуцсан ажилтнуудад зориулсан сургалт”-ыг зохион байгууллаа. Сургалтыг Ахлах мэргэжилтэн А.Нарантуяа “Статистикийн тухай хууль болон хэлтсийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээ”, “Аж үйлдвэрийн салбарын мэдээ, тайлан гаргах арга аргачлал”, мэргэжилтэн Г.Нандин “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан-[www.1212.mn](http://www.1212.mn)”, “Тээвэр холбооны мэдээ,

## Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс

тайлан гаргах арга аргачлал”, гэрээт ажилтан Ж.Мөнхзул “Барилгын салбарын мэдээ, тайлан гаргах арга аргачлал” сэдвүүдээр хичээл заан, мэдээнд ихэвчлэн гардаг алдаа, дутагдлыг анхааруулж, заавар, зөвлөгөө өгч ажиллалаа. Сургалтанд нийт 16 ажилтан оролцов. Сургалтанд оролцогчдод гарын авлага, бал, дэвтэр тараалаа.



2016 оны 5 сарын 16-17-ны өдрүүдэд УБСЕГазрын даргын 4/5475 тоот албан бичгийн дагуу Орхон, Булган аймгийн, сумдын улсын бүртгэгч, статистикийн ажилтнуудад, НБХАГазрын дарга Бадамцэцэг “Бүртгэл, статистикийн үйл ажиллагаа, сумын бүртгэгч, статистикийн ажилтны чиг үүрэг”, ахлах бүртгэгч Б.Нарангэрэл “Сонгуулийн тухай хууль, сонгуулийн бэлтгэл ажилд анхаарах асуудал”, “Сонгуулийн бэлтгэл ажлын явцын талаар танилцуулга”, Орхон аймгийн СХ-н дарга Д.Эрдэнэчимэг “Иргэний бүртгэлийн мэдээллийн сан болон ХАӨМСангийн тулгалт, анхаарах асуудал”, “Хүн амын статистикийн мэдээлэл цуглуулалт, анхаарах асуудал”, хэлтсийн дарга Ц.Ганцэцэг “Хүн ам, өрхийн мэдээллийн сан, мал тооллогын мэдээллийн сан, статистик мэдээлэл дамжуулах программ” сэдвүүдээр тус тус хичээл заалаа. Сургалтанд нийт 26 албан хаагч оролцлоо.



2016 оны 05-р сарын 20-нд өдрүүдэд “Статистикийн боловсрол олгох” сургалтыг Хутаг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийнханд зохион байгууллаа. Сургалтыг мэргэжилтэн Г.Нандин “Статистикийн боловсрол олгох” хичээл, “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан-[www.1212.mn](http://www.1212.mn)”, “[Bulgan.ubseg.gov.mn](http://Bulgan.ubseg.gov.mn)” веб сайт, байгууллагын үйл ажиллагааг таниулах таниулан, статистикч мэргэжлийн талаарх мэдээллийг өгч байгууллагын үйл ажиллагааг сурталчилав. Сургалтанд нийт 120 суралцагчид оролцов.

## Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс




2016 оны 5 сарын 30-нд Рашаант сумын ахлах ангийн нийт 28 суралцагчдад “Статистикийн боловсрол” хичээл, “Бүртгэл статистикийн байгууллагын тогтолцоо”ны тухай мэдээлэл өгч сургалт зохион байгууллаа. Сургалтын үеэр статистикийн үзүүлэлт, статистикийн мэдээллийг хаанаас авч болох вэ, [www.1212.mn](http://www.1212.mn), [www.bulgan.ubseg.gov.mn](http://www.bulgan.ubseg.gov.mn)



сайт, статистикийн шинжлэх ухааны ач холбогдлыг таниулан, статистикч мэргэжлийг танилцуулж ажилласан.

2016 оны 10 сарын 06-нд Бүрэгхайнгай сумын төсвийн мэргэжилтэн Д.Оюунгэрэлд “Бичил уурхайн судалгаа”-ны сургалтыг хийж гарын авлага, бал, дэвтэр, хавтасыг тараасан.


ТЭГЭР	ТӨСВИЙН МЭРГЭЖИЛТЭН	МЭРГЭЖИЛТЭН
08:00-09:15	Бичил уурхайн эрхлэгчдийн судалгааны үрэлт	Ахлах мэргэжилтэн А.Нарантуяа
09:15-10:30	Бичил уурхайн эрхлэгчдийн судалгааны үрэлт	Ахлах мэргэжилтэн А.Нарантуяа
10:30-11:45	Бичил уурхайн эрхлэгчдийн судалгааны үрэлт	Ахлах мэргэжилтэн А.Нарантуяа
11:45-13:00	Бичил уурхайн эрхлэгчдийн судалгааны үрэлт	Ахлах мэргэжилтэн А.Нарантуяа
13:00-14:15	Бичил уурхайн эрхлэгчдийн судалгааны үрэлт	Ахлах мэргэжилтэн А.Нарантуяа
14:15-15:30	Бичил уурхайн эрхлэгчдийн судалгааны үрэлт	Ахлах мэргэжилтэн А.Нарантуяа
15:30-16:45	Бичил уурхайн эрхлэгчдийн судалгааны үрэлт	Ахлах мэргэжилтэн А.Нарантуяа
16:45-18:00	Бичил уурхайн эрхлэгчдийн судалгааны үрэлт	Ахлах мэргэжилтэн А.Нарантуяа
18:00-19:15	Бичил уурхайн эрхлэгчдийн судалгааны үрэлт	Ахлах мэргэжилтэн А.Нарантуяа
19:15-20:30	Бичил уурхайн эрхлэгчдийн судалгааны үрэлт	Ахлах мэргэжилтэн А.Нарантуяа
20:30-21:45	Бичил уурхайн эрхлэгчдийн судалгааны үрэлт	Ахлах мэргэжилтэн А.Нарантуяа
21:45-23:00	Бичил уурхайн эрхлэгчдийн судалгааны үрэлт	Ахлах мэргэжилтэн А.Нарантуяа




Сургалтын төлөвлөгөөний дагуу 2016 оны 10-р сарын 11-ны өдөр Булган сумын багийн дарга, төсвийн мэргэжилтэн, хөдөө аж ахуйн мэргэжилтэн нарт сургалт зохион байгууллаа. Сургалтыг мэргэжилтэн Б.Болормаа, Г.Нандин нар “Газар тариалангийн

## Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс

мэдээ, тайлан гаргахан анхаарах асуудал”, “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан-  
[www.1212.mn](http://www.1212.mn)”, “[Bulgan.nso.mn](http://Bulgan.nso.mn)” веб сайт, статистикийн шинжлэх ухааны ач холбогдлыг  
таниулан мэдээллийг өгч ажиллалаа. Сургалтанд нийт 6 албан хаагчид оролцосон.



Хугацаа	Сэдэв	Илтгэгч / Мэргэжилтэн
10.00-10.05	Ирцлийн бүртгэл	Б.Болоржав / мэргэжилтэн
10.05-10.25	Газар, ус, цагаан усны мэдээллийн системийн үйлчилгээний асуудал	Б.Болоржав / мэргэжилтэн
10.25-11.35	Асуулт, баримт	Б.Болоржав / мэргэжилтэн
11.35-12.25	Статистикийн мэдээллийн системийн үйлчилгээний асуудал	Г.Шарваан / мэргэжилтэн
12.25-12.55	Асуулт, баримт	Г.Шарваан / мэргэжилтэн
13.00-13.05	Асуулт, баримт	Г.Шарваан / мэргэжилтэн



Сургалтанд оролцогчдод “статистик хөгжилд хөтлөгч хүч” дэвтэр, “[www.1212.mn](http://www.1212.mn)” бал, гарын авлага тараалаа.



2016 оны 10 дүгээр сарын 25-ны өдөр сумдын төрийн сангийн төрийн сангийн мэргэжилтэн нарт “Албан ёсны болон мэдээ, тайлан, тооллого судалгаанд анхаарах асуудал” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтын төлөвлөгөө гарган хэлтсийн даргаар батлуулан, сургалтанд оролцогчдын ирцыг бүртгэн, цайны материалыг тараасан гарын үсэг зуруулан баримтыг санхүүд хүлээлгэн өгч ажиллалаа. Сургалтанд нийт 17 албан хаагч хамрагдсан.



## Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс

“Статистикийн боловсрол олгох” сэдэвт сургалтыг Статистикийн алба үүсч хөгжсөний 92 жилийн ойг тохиолдуулан Булган сумын Ерөнхий боловсролын 1,2-р 12 жилийн сургуулийн суралцагчдын дунд явууллаа. Сургалтанд нийт 106 суралцагчид оролцлоо. Сургалтанд “Статистикийн боловсрол олгох”, “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан-[www.1212.mn](http://www.1212.mn)”, “[Bulgan.nso.mn](http://Bulgan.nso.mn)” веб сайт, статистикийн шинжлэх ухааны ач холбогдлыг таниулах мэдээллийг өгч ажиллалсан. Сургалтанд оролцсон сурагчдын дунд статистикийн тухай хэрхэн ойлголт, сонирхолтой статистик асуулт, АХА тэмцээн зохион байгуулж, зөв хариулсан 6 сурагчдад гарын бэлэг гардуулсан.



2016 оны 12 сарын 02-ны өдөр Орон нутгийн ээлжит сонгуул болж сумдын удирдлага болон багийн Засаг дарга нар шинээр томилогдсонтой холбогдуулан багийн Засаг дарга, төсвийн мэргэжилтэн нарт “Статистикийн анхан шатны нэгжийн ажилтнуудын эрх, үүрэг, оролцоо”, “Мэдээ, тайланг цуглуулах, дамжуулах, боловсруулах, сурталчилах” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд нийт 74 хүн оролцлоо. Сургалтанд зориулж аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 261.7 мянган төгрөгийг зарцуулсан.





### Ш 11: Сурталчилгаа:

Байгууллагын үйл ажиллагаа, [www.1212.mn](http://www.1212.mn), тооллого судалгааны дүнг сурталчлах ажлыг дараах байдлаар сурталчилан ажиллалаа.



## Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс



Аймгийн нийгэм эдийн засгийн танилцуулгыг [www.YouTube.com](http://www.YouTube.com), [www.facebook.com](http://www.facebook.com) дээр тавьж интернэт хэрэглэгчдэд хүргэж ажиллаж байна.



ААНБУТооллогын сурталчилгааг Булган суманд байрлах LED дэлгэц, зах, дэлгүүр, худалдааны төвүүдийн мэдээллийн самбарт байрлуулж, богино долгионы чанга яригчаар Булган сумын зах, томоохон худалдааны төв, гэр хорооллоор явж сурталчиллаа.



Аж ахуйн нэгж байгууллагын дарга, захирал, нягтлан бодогчийн нийт 1537 үүрэн телефон хэрэглэгчидэд тооллогод хамрагдахыг уриалсан захидлыг /мэссэж/ явуулж ажиллаа.



## Ш 12: Вэб баяжилт:

### 1. Байгууллагын танилцуулга:

Байгууллагын танилцуулгыг 2016 оны 1-р сарын 30-ны өдөр вэб сайтад байршуулсан.



Эдгээр өдөр зурагт харгалзан С.Оюунмаа, нийтлэн-Бадарх Ж.Чануулун, дарга Ц.Ганзориг, гэрээт ажилтан Ж.Мөнхтүвшин, шатрынхон Б.Болорсүх



Эдгээр өдөр зурагт харгалзан Д.Халуун, Гэрээт ажилтан Ж.Мөнхтүвшин, Хэлтсийн дарга Ц.Ганзориг ахуйн мэргэжилтэн А.Нарантуяа, мэргэжилтэн Б.Болорсүх

Хэлтсийн албан хаагчдын бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тул 2016 оны 4-р сарын 2-ны өдөр хэлтсийн танилцуулгыг дахин шинэчилсэн. Мөн хэлтсийн вэб сайтыг УБСГ-ын вэб сайт болгон хөгжүүлэх ажлын хүрээнд 2016 оны 4-р сарын 2-ны өдөр Бүртгэлийн хэлтсийн танилцуулгыг вэб сайтад байршуулсан.

### 2. Бюллетень, танилцуулга:

Сар бүрийн бюллетень танилцуулгыг бэлтгэн графикт хугацаанд нь “pdf” өргөтгөлөөр татах болон үзэхээр вэб сайтад байршуулан ажиллаж байна. Линк: <http://bulgan.ubseq.gov.mn/page/445>



3.Шинэ мэдээ мэдээлэл: Сарын мэдээллээр хийх хэвлэлийн бага хурлыг аймгийн онцлогоос шалтгаалан зохион байгуулах боломжгүй байгаа тул сарын танилцуулгаар видео танилцуулга бэлтгэн вэб сайтад графикт хугацаанд нь байршуулан ажиллаж байна. Линк: <http://bulgan.nso.mn>




2016 оны 5 сарын Видео танилцуулга




4.Нийслэл аймгийн статистикийн үзүүлэлт Хүн амын динамик: Булган аймгийн хүн амын динамикийг 1997-2015 оны мэдээллээр сумаар, хүйсээр, 2004-2015 оны мэдээллээр багаар гаргаж 2016 оны 4-р сарын 30-ны өдөр вэб сайтад байршуулсан.

Линк: <http://bulgan.nso.mn>



Хөдөө аж ахуйн динамик: Булган аймгийн хөдөө аж ахуйн динамикийн 2016 оны 4-р сарын 1-ны өдөр вэб сайтад байршуулан ажилласан. Мал аж ахуйг 1980-2015, газар тариаланг 2000-2015 оны мэдээллээр .pdf, .xls өргөтгөлөөр татаж үзэхээр. Линк: <http://bulgan.nso.mn>



Инфографик: Аймгийн инфографик танилцуулгыг сар болгон

- \* Эрүүл мэнд
- \* Хөдөлмөр
- \* Нийгмийн даатгал
- \* Гэмт хэрэг
- \* Аж үйлдвэр
- \* Үнэ

\* Төсөв

\* Хөдөө аж ахуй зэрэг салбаруудаар бэлтгэн Вэб сайтад байршуулан ажиллаж байна.  
Линк: <http://bulgan.nso.mn>

Жилийн эцсийн танилцуулга: 2015 оны хөдөө аж ахуйн танилцуулгыг 4-р сарын 1 нд, Хүн амын танилцуулгыг 4-р сарын 30нд, Аж үйлдвэр, барилга, тээвэр, холбооны салбарын танилцуулгыг 6-р сарын 14 нд тус тус вэб сайтад татаж үзэхээр байршууллаа. Линк: <http://bulgan.nso.mn>



### ЖИЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Он	Нэр	Дэлгэрэнгүй
2015	Жилийн эмхэтгэл	Татаж үзэх
	Ажил эрхлэлтийн танилцуулга	Татаж үзэх
	Аж үйлдвэр, барилга, бизнес регистр, тээвэр холбооны салбарын танилцуулга	Татаж үзэх
	Хүн амын танилцуулга	Татаж үзэх
	Хөдөө аж ахуйн танилцуулга	Татаж үзэх
2014	Хүн амын танилцуулга	Татаж үзэх
	Хөдөө аж ахуйн танилцуулга	Татаж үзэх
	Ажил эрхлэлтийн танилцуулга	Татаж үзэх
2013	Аж үйлдвэр барилга, үйлчилгээний салбарын танилцуулга	Татаж үзэх
	Хүн амын үзүүлэлт	Татаж үзэх
	Мал тооллогын үр дүн	Татаж үзэх
	Аж үйлдвэрийн салбарын танилцуулга	Татаж үзэх
	Сумдын нийгэм эдийн засгийн үзүүлэлт /2009-2013/	Татаж үзэх

### Ш 13: Мэдээлэл тархаалт:

Сар бүрийн “аймгийн нийгэм эдийн засгийн байдлын танилцуулга”, Хүн амын танилцуулга “Хөдөө аж ахуйн салбарын 2015 оны танилцуулга”, “Аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын танилцуулга”, Сар бүрийн аймгийн нийгэм эдийн засгийн байдлын видео бичлэг, мэдээллийн өрөөнд байрлах электрон самбараар, Булган сумын төвд байрлах “LED” дэлгэцээр сар бүрийн 15-аас 25-ны өдрүүдэд нэвтрүүлэн ажиллаж байна. Аймгийн нийгэм эдийн засгийн сар бүрийн танилцуулга, инфографик, нугалбарыг нийт . . .

## Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс

ширхэгийг хэвлэн тархаалаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад . . . хувиар өссөн байна. Статистикийн мэдээллийг . . . хэрэглэгчдэд цаас, цахимаар, 70342766 утсаар тархаан ажиллаа. 1-р сарын 25-27 өдрүүдэд Булган суманд зохион байгуулагдсан “Цагаан сар 2016” үзэсгэлэн худалдааны үеэр Аж үйлдвэрийн мэдээний гарын авлага тархаан, ААНБ-1, 2 маягтын заавар, аргачлал, 2016 оны аймгийн Засаг даргын А/2 тоот захирамж “Албан ёсны болон захиргааны мэдээ” ирүүлэх графикийг тархааж үзэсгэлэнд оролцсон 60 иргэн, 20 ААНБ-аас шинээр үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний судалгааг гаргуулан авсан.



5-р сарын 6-ны өдөр Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсээс зохион байгуулсан “Мэргэжил бүхэн сайхан” арга хэмжээнд оролцож Улсын бүртгэл статистикийн газрын үйл ажиллагаа, тухайн мэргэжлийг сонгоход шаардлагатай мэдээллийг төгсөх ангийн суралцагчдад болон арга хэмжээнд хүрэлцэн ирсэн хүмүүст өгч ажиллалаа. Булган аймгийн нийгэм эдийн засгийн танилцуулга, нугалбар, инфографик нийт 60 ш-г тархааж, бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгчид сурталчилав.




5-р сарын 25-ны өдөр Аймгийн засаг даргын удирдамжийн дагуу зохион байгуулагдсан “Нээлтэй хаалганы өдөр” арга хэмжээнд оролцон байгууллагын үйл ажиллагаа, “аймгийн нийгэм эдийн засгийн байдал” танилцуулга, инфографик нугалбар нийт 100 ш тархаан ажиллалаа.



6-р сарын 1 -ны өдөр буюу “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр” -т зориулан Булган аймгийн 0-18 насны хүүхдүүдийн статистик болон аймгийн нийгэм эдийн засгийн зарим үзүүлэлтийг багтаасан цэцгэн хэлбэртэй иштэй чихэртэй нугалбар 120ш хийж тархаасан.



УБСЕГазрын даргын 1/133 тоот “Судалгаанд хамруулах тухай” албан бичгийн дагуу салбар хоорондын тэнцэл, нөөц ашиглалтын хүснэгтийн судалгаанд зориулан нөөц ашиглалтын хүснэгтийн нугалбар 36ш хийж судалгаанд хамрагдсан аж ахуй нэгж байгууллагад тархаасан.



2015 оны Хөдөө аж ахуйн салбарын танилцууллагыг бэлтгэн байгууллага, агентлаг, аж ахуйн нэгжид 28 хувь, бүх сумдад 17 хувь хүргүүлж тархааж, тархаалтыг бүртгэл хөтлөн ажиллалаа. Булган сумын төвд байрлалтай сурталчилгааны “Led” дэлгэц, мэдээллийн өрөөнд байрлах электрон самбараар 2015 оны хөдөө аж ахуйн салбарын танилцуулгыг бэлтгэн нэвтрүүлж статистикийн үйл ажиллагааг иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулж байна.

## Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс



2015 оны Хүн амын танилцуулгыг бэлтгэн байгууллага, агентлаг, аж ахуйн нэгжид 24 хувь, бүх сумдад 17 хувь хүргүүлж нийт 41 хувь тархаан ажиллалаа. Мөн вэб сайтад байршуулан е-мэйлээр 16 сум 1 тосгонд хүргүүллээ.



7-р сарын 19-өөс 22-ны өдрүүдэд Аймгийн Улсын баяр наадмын өдрүүдэд Булган аймгийн газрын зургийн хэлбэртэй сонирхолтой статистик тоон мэдээллийг агуулсан танилцуулга 250 ш хийж тараан ажиллалаа.





Аймгийн Засаг даргын нэгдсэн удирдамжаар Нээлттэй хаалганы өдөрлөгийг Булган сумын 1, 3-р багт хэлтсийн мэргэжилтэнүүд зохион байгууллаа. “Статистикийн албаны түүхт 92 жилийн ой”-г угтан байгууллагын үйл ажиллагаа, цаашдын зорилго, зорилт үйл ажиллагааг иргэдэд сурталчилж, аймгийн нийгэм эдийн засгийн сүүлийн 5 жилийн үзүүлэлтээр нийт 5 төрлийн танилцуулга, 5 төрлийн нугалбар, боршур 210 ш гаргаж тархаан ажилласан.



Нээлттэй хаалганы өдөрлөгөөр хэлтсийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг өгч, сурталчилан хэлтсийн үйл ажиллагааны талаарх санал асуулга авлаа. Санал асуулганд нэлээдгүй сонирхолтой хариулт өгсөн байна. Жишээ нь: Та статистикийн тухай ерөнхий ойлголттой юу. Өөрийн ойлголтоороо статистикийг тодорхойлно уу гэсэн асуултанд- тооцоолол тоо бүртгэл судлал, статистик гэж нийгмийн бүх салбарын үйл ажиллагааг тоон үзүүлэлтээр хэмжиж гаргасан



мэдээллийг хэлнэ, тоо мэдээ судалгаа, нийгмийн үзүүлэлтүүдийн судалгаа гэж хариулсан бол аливаа мэдээ судалгааг бодит байдлаар гаргаж тухайн тоо мэдээ баримтанд тулгуурлан бодлого боловсруулахад хэрэглэгдэхүүн болдог, статистик нийгмийн хөгжлийн өчигдөр өнөөдөр маргаашийг тодорхойлох толь, улс орны тоон мэдээллийг үнэн зөвөөр гаргах зүйл, улс аймаг сум багийн төрийн мэдээ судалгааг гаргаж нэгтгэгч гэсэн хариултуудыг өгсөн нь статистикийн талаарх хүмүүсийн ойлголт нь чамлахааргүй байгаа нь энэхүү санал асуулгаас харагдаж байна.



### **БҮЛЭГ III. Хяналт үнэлгээний үр дүн, төлөвлөлт, тайлагналт, төсөвт хөрөнгийн зарцуулалт ашиглалт**

#### **Ш14: Төлөвлөлт, тайлагналт:**

Монгол улсын статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх Булган аймгийн хөтөлбөрийг батлуулан түүнийг хэрэгжүүлэх аймгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, “Шинэ Булган” мөрийн хөтөлбөр, аймгийн даргаас “БҮТЭЭЛЧ ДААЛГАВАР” болгон өгсөн “Хүн ам өрхийн бүртгэлийн санг сайжруулах” даалгавар зэрэг холбогдох хөтөлбөр төсөл төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу төсвийн Ерөнхийлөн захирагч ҮСХорооны дарга болон аймгийн Засаг даргатай “Үр дүнгийн гэрээ” байгуулан ажиллаж, гэрээний биелэлтийг хугацаанд нь тайлагнан ажиллаж байна.

Мөн хөтөлбөрийн 93 дугаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор хэлтсийн санаачлагаар Булган сумын 5-р баг төв хэсэгт төрийн албан хаагчдын 25 айлын орон сууцны барилгын ажлыг 2015 оны 5-р сард эхлүүлэн, гүйцэтгэл 80 хувьтай байна. Тус орон сууц нь 2017 оны 5-6 сард ашиглалтанд орохоор төлөвлөгөөтэй ажиллаж байна. Орон сууцанд хэлтсийн 3 ажилтан хөнгөлттэй нөхцлөөр байр захиалсан.

Хөтөлбөрийн 98,99 дүгээр заалтыг хэрэгжүүлэн хэлтсийн ажилтан С.Оюумааг морин хуурын төлбөртэй сургалтанд сургаж, аймгийн баяр наадмын нээлтээр морин хуурын чуулганд тоглолт хийлээ. Мөн бүх ажилтнуудыг шатар хөтөлбөрт хамруулж, бүгд шатар тоглолт сурсан бөгөөд хэлтсийн шатрын тэмцээн зохион байгуулж гэрээт ажилтан Б.Нямсүрэн тэргүүллээ.

Хөтөлбөрийн 96 дугаар заалтыг хэрэгжүүлэн ажилтнуудыг 9-р сарын 15-аас 16-ны хооронд эрүүл мэндийн бүрэн үзлэг оношлогоонд хамрууллаа.

Монгол улсын статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх Булган аймгийн төлөвлөгөөний биелэлтийг 4-р улиралд аймгийн ИТХ-д танилцуулахаар ажиллаж байна.

### Ш15: Хяналт үнэлгээний үр өгөөж:

Статистикийн хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу 2016 оны 2 сарын 26-аас 29-ны өдрүүдэд Дашинчилэн, Гурванбулаг, Рашаант сумдад Хүн ам өрхийн мэдээллийн сангийн ашиглалт, Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа, Ажиллах хүчний судалгааны хяналт, жилийн эцсийн мэдээг анхан шатны нэгжээс цуглуулах, албан ёсны мэдээ тайлангийн үнэн бодит байдалд хяналт шалгалт хийн, зөвлөн туслаж ажилласан. Рашаант, Гурванбулаг сумдад ажиллаж ӨНЭЗСудалгаа, АХСудалгааны 1, 2 сард сонгогдсон нийт 50 өрхийн 38 хувь буюу 19 өрхийн цуглуулсан мэдээлэлд хяналт шалгалт хийлээ.

- ӨНЭЗСудалгааны 852-р нэгжээс С.Батдорж, Ц.Баатарсүрэн, Ц.Дорж, Ё.Гэндэн, М.Нарангэрэл, 853-р нэгжээс Т.Бадамдорж, Д.Даваасамбуу, Г.Галсан, Ч.Бат-Эрдэнэ, 852-р нэгжээс Д.Гантөмөр, Ш.Чулуунбат, Ш.Сүхбаатар, 449-р нэгжээс Д.Алтанцэцэг, Ц.Батбаатар, Х.Пүрэвбаатар, Э.Энх-Эрдэнэ, Х.Бум-Аюуш, Ө.Төрхишиг, нарын өрхөөс цуглуулсан мэдээллийг мэдээлэгчээс тодруулж шалгахад алдаагүй байна.

- Мөн өрхөд урамшуулал олгосон эсэхийг шалгаж, гарын үсгийг тодруулахад өрхийн урамшууллыг бүрэн олгосон байна.



Судлаач нарын харилцааны ур чадвар, мэдээлэгч нарт судалгааны зорилго ач холбогдлыг ойлгуулж, талархлын хуудсыг тархаасан байдлыг шалгахад хангалттай сайн байна.

Жилийн эцсийн мэдээнд ААНБ-1, 2 мэдээнд Дашинчилэн сум 36, Гурванбулаг сум 22, Рашаант сум 22, нийт 80 аж ахуй нэгжийн тайлан рүүлэхээс 15.8 хувь нь хугацаандаа ирсэн байна. Бусад аж ахуйн нэгжүүдийн холбогдох ажилтнуудадтай уулзаж мэдээ, заавар, зөвөлгөө өгч, тайлангийн хамралтыг нэмэгдүүлж 3-р сарын 1-нд бүрэн цуглуулсан байх үүрэг даалгаврыг төсвийн мэргэжилтэнүүдэд өгч ажиллалаа.



Статистик хариуцсан ажилтнуудад Өрхийн нийгэм эдийн засаг, Ажиллах хүчний судалгааны хяналтыг сар бүр хийж байх, хүн амын статистикийн бүртгэл мэдээллийн сангийн бүрдүүлэлт, ашиглалтыг сайжруулах, тухай бүр хөдөлгөөн хийх, статистикийн мэдээнд статистик нэгжийг бүрэн хамруулах, хүрээг өргөжүүлж, түгээлт, хүртээмжийг сайжруулах ажлыг дараах үүрэг даалгаврыг өгч ажилласан.

Статистикийн хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу 2016 оны 5 сарын 30-31-ны өдрүүдэд Рашаант, Баяннуур сумдад Статистикийн тухай хууль, Улсын бүртгэл статистикийн тогтолцоо, үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилах, албан ёсны мэдээ тайлангийн хамрагдалт, мэдээллийн үнэн бодит байдалд хяналт шалгалт хийн, зөвлөн туслаж, цаашид хийх ажил, анхаарах асуудал, үүрэг даалгавар өгч ажилласан. Рашаант, Баяннуур сумдад ӨНЭЗСудалгаа, АХСудалгааны мэдээлэл цуглуулалтад нийт 13 өрхөд хяналт шалгалт хийн ажиллалаа. Хяналт шалгалтаар судлаачийн цуглуулсан мэдээлэл үнэн зөв эсэхийг өрхийн гишүүнээс асуун тулгалт хийхэд алдаа дутагдал гарсангүй. Мөн судлаач нарын өрхөөс хэрхэн мэдээлэл цуглуулж байгаатай танилцсан. Анхан шатны нэгжээс мэдээллийг бүрэн, алдаагүй цуглуулж, өрхөд олгох урамшууллыг олгож, мэдээлэгчтэй найрсаг харьцан, судалгааны ач холбогдол болон бусад мэдээллийг үнэн зөв өгч ажилласан байсан. Судалгаа авах үеэр сонгогдсон өрхийн гишүүд согтуу байх, хөдөө явсан гэх тохиолдол гарч байлаа.



## Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс

Сумдад аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан албан ёсны мэдээ, тайлангийн графикийн дагуу анхан шатны нэгжээс цуглуулсан, хөтөлсөн, сар, улирал, жилээр нь үдэж, архивлаж, хадгалсан байдалтай танилцахад Рашаант сум хангалттай үзүүлэлттэй байлаа. Баяннуур сумын ХАА-н сарын мэдээ өмнөх сараас буурсан, мэдээ, тайлангийн цуглуулалт, хадгалалт хангалтгүй байсныг заавар зөвөлгөө өгч, мэдээ тайлангийн маягтыг бүрэн болгож, үдэж цэгцлэх, хугацаатай үүрэг даалгавар өглөө.



Томилолтоор ажилласан сумдад ХАӨМСийн баяжилт, ашиглалтыг сайжруулж, тухай бүр нь хөдөлгөөнийг хийх, статистик мэдээний хүрээг өргөжүүлж, сар бүр сумын нийгэм эдийн байдал танилцуулга, статистик мэдээ, мэдээллийг гарган, тархаах, түгээлт, хүртээмжийг сайжруулах, шинээр болон үйл ажиллагааны чиглэлээ өөрчилж буй аж ахуй нэгж, иргэний үйлдвэрлэл үйлчилгээг мэдээ, тайланд бүрэн хамруулахыг төсвийн мэргэжилтэн, багийн Засаг нарт хугацаатай өгсөн үүрэг даалгаврыг өгч ажилласан. Цаашид албан ёсны мэдээ, тайланг үнэн бодит байдалд хяналт шалгалтыг тогтмол хийж байх, сумдын статистик хариуцсан ажилтан, багийн Засаг дарга нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалтыг тогтмол давтамжтай хийж байх, Өрхийн нийгэм эдийн засаг, Ажиллах хүчний судалгаанд хяналт, шалгалтыг тогтмол хийж байх саналуудыг өгч ажилласан.



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мэдээний хяналтыг Булган сумын “Арвайн эхлэл” цех, “Дэлгэрэх цех, “Булган кашмер”ХХК-д хийж, мэдээ тайлан гаргах аргачлал, заавар зөвлөгөөг өгч ажилласан.

Статистикийн хэлтсийн даргаар батлуулсан удирдамжийн дагуу Булган сумын 1,2,3,4,6-р багт нийт 14 өрхийн тариалсан талбай, хураасан ургацын мэдээнд хяналт шалгалт хийж ажилласан.



Хяналтаар 1 өрх огт тариалалт байхгүй, 2 өрхийн тариалсан талбайн хэмжээ өгсөн мэдээнээс бага гарсан зэрэг зөрчил дутагдал гарсныг багийн дарга, ХАА-н мэргэжилтэн болон төсвийн мэргэжилтэнд сануулга өгч цаашид зөрчил дутагдал гаргахгүй ажиллахыг анхааруулж заавар зөвлөмж өгч ажилласан.

Хэлтсийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын дагуу Нийгмийн даатгал, Татварын хэлтэс, Төрийн сантай хамтарсан анхан шатны баримт бүрдүүлэлт, санхүүгийн тайлангийн үнэн бодит байдалд хянаж шалган зөвлөн туслая уриан дор хэлтсийн ахлах мэргэжилтэн А.Нарантуяа, мэргэжилтэн Г.Нандин нар 12 сарын 10-аас 12-нд сар, улирлын мэдээнд хамрагдсан 15 аж ахуй нэгжид анхан шатны мэдээний баримтанд шалгалт хийж гарсан алдааг нь залруулж заавар зөвлөгөө өгөн ажилласан.



### Ш16: Санхүүгийн үйл ажиллагаа:

2015 оны хэлтсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд аймгийн Аудитын газраар баталгаажуулж зөрчилгүй санал, дүгнэлттэй гарч УБСЕГазар хүргүүлж ажиллалаа. 2016 оны төсөвт батлагдсан санхүүд Нийгмийн даатгалын шимтгэлийн 1166278 төгрөгийн өр, 803800 төгрөгийн цалингийн өглөгтэй байна. ӨНЭЗ-ийн судалгаа, АХСудалгаа, бусад тооллого судалгааны санхүүгийн зардлыг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж байна.

### Ш17: Бусад ажлын талаар:

Булган аймгийн Төв номын сантай хамтран “Ном уншлагын 14 хоногийн аян”-г хэлтсийн хамт олны дунд зохион байгуулж байна. Энэ ажлын хүрээнд “Чанга шивнээ” хөгжөөнт тэмцээнийг зохион байгууллаа.



Булган сумын төрийн болон бөрийн бус байгууллага, аж ахуй нэгж, ард иргэдийн дунд зохион байгуулагдсан “БУЛГАН КАП-2016” багийн аварга шалгаруулах кросс гүйлтийн тэмцээнд Улсын бүртгэл статистикийн газрын хамт олон амжилттай оролцож 3-р байр эзэлж хүрэл медаль хүртлээ.



Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэстэй хамтран “Бусдын төлөө зүрх сэтгэлээ зориулцаа - 2” сайн үйлсийн аянд дуудагдан, хөгжлийн бэрхшээлтэй Булган сумын 3-р багийн иргэн Байгалийн гэр бүлд дэмжлэг үзүүлж цагаан сарын гарын бэлэг гардууллаа.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн 63 дугаар зарлигаар “Мод тарих үндэсний өдөр”-ийг зарласантай холбогдуулан цэцэрлэгт хүрээлэнд өмнө жилүүдэд тарьж ургуулсан модоо тордож, арчиллаа.

Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсээс зохион байгуулсан "Мэргэжил бүхэн сайхан" арга хэмжээнд 5-р сарын 6-ны өдөр оролцож Улсын бүртгэл статистикийн газрын үйл ажиллагаа, тухайн мэргэжлийг сонгоход шаардлагатай мэдээллийг төгсөх ангийн суралцагчдад болон арга хэмжээнд хүрэлцэн ирсэн хүмүүст мэдээлэл өгч ажиллалаа.



Булган аймгийн Засаг даргын захирамжаар бүх нийтийн цэвэрлэгээний аян зарлагдсаны дагуу байгууллага хамт олноороо Булган аймгийн Булган сумын 5 дугаар багийн төв замын шуудууг цэвэрлэн ажиллаа.



## Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс

Жил бүрийн 10 дугаар сарын 1-ний ахмадын өдрөөр байгууллагаас тэтгэвэрт гарсан 2 ахмадад тус бүр 30000 төгрөгний гарын бэлэг гардууллаа.

Булган сумын Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/177 захирамжийн дагуу бүх нийтийн цас цэвэрлэх ажилд хэлтсийн албан хаагчид ноогдсон талбайн цасыг арилгах ажилд идэвхтэй оролцлоо.



Тайлан бичсэн:

/А.Нарантуяа/

/Ц.Батчимэг/

/Г.Нандин/

/Б.Нямсүрэн/

/Ж.Мөнхзул/

Хянасан:

/М.Мөнхбат/

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2016 оны 12-р сарын 22